



MNG56 Сумын төвийг салхинаас хамгаалах ойн зурвас

Ховд аймгийн Зэрэг сум Мөст, Манхан, Дарви, Чандмань зэрэг сумуудтай хиллэнэ. Улаанбаатар хотоос 1389 км, аймгийн төвөөс 141 км оршдог.

Одоогийн байдлаар Зэрэг сум нь 240 гаруй га нутагтайгаас 220 га нь хадланд, 180 га нь тариаланд бусад нь бэлчээрийн зориулалтаар ашиглагддаг нутаг юм. Баруун зүгн хоёр ууландаа цагаан борог, үүргэнэ, агь, уулын дунд бүснээс доош шаваг, таана, шарилж, багалуур зэргийн төрөл бүрийн ургамалтай.

Тус сумын хувьд салхи дээд тал нь 47м/сек хүртэл салхилдаг ба хавар 1-4-р сар, намар 10-11-р саруудад тогтмол хүчтэй салхи болдог байна. Үүнээс үүдэж айл өрх, албан байгууллагын дээвэр нурах, цонх хагарах зэрэг эдийн засгийн болон ихээхэн эрсдэл хохиролыг дагуулдаг байна.

Иймээс Зэрэг сумын төвийг хүчтэй салхин болон шороон шуурганаас хамгаалах, ард иргэдийн тав тухтай нөхцлийг бүрдүүлэх, хангах зорилготойгоор “Ногоон хэрэм” төслийн хүрээнд Зэрэг сумын ЗДТГ-аас сумын төвийн урд талд салхинаас хамгаалах ойн зурвасыг 1000м урт, 40 м өргөтэйгөөр 2005 оны 4-р сард байгуулсан байна.

Тус хамгаалалтын ойн зурвас нь ёроолоосоо оройгоо хүртэл жигдрэлийн 3 үед мод сөөгийг өндрийн дарааллаар шигүүгээр байрлуулдагаас салхийг бараг нэвтрүүлдэггүй. Нягт хийцтэй ойн зурвасны титмийн битүүрэл дээд, доод талаараа 10%-аас илүүгүй байна. салхи ийм хийцтэй зурвасанд тулж ирээд хаагдан хуулирал үүсгэж зурвасны оройгоор даван доош бууж тодорхой хэмжээний зайд задгай газарлуугаа маш хурдтай салхилдаг. Энэ үед салхи харьцангуй богино зайд эхнийхээ хурдад хүрэх тул хамгаалах зай богино байна. Ойн зурвасны өндөр 10м гэж үзвэл түүнээс 120 метрийн зайд салхины хурд 50-60%-иар, 200 метр зайд 30-40%-иар буурна.

Ойн зурвас нь зонхилох салхины чиглэлийг хааж байгаа талдаа өөрийн өндрийн 5 дахины зайд, эсрэг талдаа 30 дахины хэмжээнд тус тус бууруулна.

Ойн зурвасын талбайг тойруулан модон шонтой төмөр торон хашаагаар хашаалж улиас, бургасаар 1 га-д 800ш байхаар тооцон эгнээ хооронд 1м, эгнээ хайрцаг хоорондын хөндлөн зай 1м, ургамал хоорондын зай 15 м байхаар бэлэн ёуулгацаар тариалсан байна. Ойн зурвасны дотор талбайд тарьсан моднуудыг жил бүр дараалалтайгаар суулгаж тарьсан байна.

Одоогийн байдлаар 15200 бургас, 6000 улиас тарьсан байна.



Байршил: Ховд аймаг Зэрэг сум
Технологийн хамрах хүрээ: 4 га газар
Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл: Ургамлын

Газар ашиглалтын төрөл: Ямарч ашиглалтгүй эзгүй газар байсан бол технологи нэвтрүүлсний дараа ойн зурвас болсон

Уур амьсгал: Хуурай, сэрүүн
MONCAT мэдээллийн сангийн нэрзүй: MNG56

Холбогдох арга барил: Бүртгэгдээгүй
Технологийг нэвтрүүлсэн: Зэрэг сумын ЗДТГазар

Технологийн талаарх мэдээллийг өгсөн: Д.Батсүх





Технологийг бүртгэсэн: Геоэкологийн хүрээлэн Д.Даш

Он, сар, өдөр: 2011.09.13

Эмхэтгэгчдийн тайлбар: Энэхүү технологи нь төв суурин газрын ойролцоо агро-ойжуулалт хийх үндсийг тавьснаараа онцлог юм. Ийнхүү ойн зурвасыг байгуулснаараа сумын төвийг хүчтэй цасан болон шороон шуурганаас хамгаалж чадсан бөгөөд Томоохон суурин газруудын төв орчмын бүсд хэрэгжүүлэх боломжтой.

Ангилал

Газар ашиглалтанд тулгарч буй асуудал: Маш хүчтэй шороон болон цасан шуурганаас болж хөрс элэгдэж эвдрэх, ургамал бүрхэвч сийрэгжих, элсний нүүлт ихсэх


<p>Газар ашиглалт</p>  <p>Сумын төв</p>	<p>Уур амьсгал</p>  <p>Хуурай сэрүүн</p>	<p>Доройтлын хэлбэр</p>  <p>Салхины элэгдэл</p>	<p>Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл</p>  <p>Ургамлын: Мод тарих, ойн зурвас</p>
<p>Техник үүрэг/үзүүлэх шууд нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> - Өнгөн хөрсний бүтцийг сайжруулах - Хөрсөн дэхь органик нэгдлийн агууламжийг нэмэгдүүлэх - хөрсний ус нэвтрүүлэх, барих чадавхийг Нэмэгдүүлэх - салхины хүчийг сааруулах - ургамлын төрөл зүйлийг нэмэгдүүлэх 		<p>Техник үүрэг/үзүүлэх дам нөлөө:</p> <ul style="list-style-type: none"> - Суурин газрын ойролцоо байгаль, экологийн таатай нөхцөл бүрдэнэ 	

Байгаль орчин

<p>Жилийн дундаж хур тунадас (мм)</p> 	<p>Өндөршил (д.т.д м)</p> 	<p>Гадаргын хэлбэр</p> 	<p>Налуужилт (%)</p> 
<p>Хөрсний гүн (см)</p> 	<p>Ургамал ургах хугацаа: 100-130 өдөр (5-8 сар) Хөрсний үржил шим: Дорой Хөрсний бүтэц: Элсэрхэг Гадаргын чулуурхаг байдал: Чулуу багатай Органик бодисын хэмжээ: Бага (0,6-1%) Ус нэвтрүүлэх чадвар: Муу Элэгдэл эвдрэлд өртөх байдал: Хүчтэй</p>		<p>Агаарын жилийн дундаж температур: 4 C⁰. Хамгийн их/бага температур: +39/-36 Агаарын хамгийн их/бага даралт: 10 сард 873 /мб/, 3сард 827 /мб/ Агаарын жилийн дундаж даралт: 851.7 /мб/ Нарны гийгүүлэлтийн үргэлжлэх хугацаа: Жилд 3120 цаг, 5-6 р сар буюу хамгийн ихдээ 315 цаг, 12-р сар буюу хамгийн багадаа 200 цаг байдаг байна.</p>

Нийгэм-эдийн засаг

Нэг өрхөд ногдох ойтой талбай (га)



Газар ашиглалтын эрх: Нээлтэй
Газар эзэмшсэн эсэх: Нийтийн/Төрийн
Зах зээлийн төрөлжилт: Холимог (амь зуух, арилжаа наймаа)
Шаардагдах техник мэдлэгийн түвшин: Дунд: мэргэжилтэн/нэмэлт ажилчид
ХАА-аас гадна олох орлого, түүний ач холбогдол: 10-50%

Суурин/нүүдэлчин: Суурин
Ядуурлын түвшин: Дунд
Ажилгүйдлийн түвшин: Дунд
Нийгмийн зохион байгуулалт: Сайн

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, үнэ өртөг

Үйл ажиллагааны дараалал	Байгуулахад гарах зардал /1 худаг гаргахад/, 1 \$-ыг 1000 төгрөгөөр бодов		
	Хөрөнгө оруулалт	өртөг (US\$)	Газар ашиглагчаас гарах %
1. Хамгаалалтын торон хашаа барих	Төмөр тор /4000 м, 1 м-ийн үнэ 300₮	1200000	0%
2. Усалгааны худаг гаргах	Модон шон / 700 ш, нэг бүрийн үнэ 3000₮	2100000	0%
3. Усалгааны шуудуй татах	Хадаас / 10кг, 1 бүрийн үнэ 350₮	35000	
4. Суулгац хадалдаж авах	Шонгын нүх ухах /6 хүн, 1 хүний цалин 31667₮	190000	0%
5. Суулгац тарих	Мөчир авах /6000 ш улиас , 1 бүрийн үнэ500₮, бургас мөчир 14000ш 1 бүрийн үнэ 500, тээврийн зардал 160000/	10160000	0%
	Мөчир тарих / мөчир тарих 12 хүн, 1 бүрийн үнэ 40000₮,усалгаа 1 га 150000, ажилчдын цалин 1080000	1560000	0%
	Усалгааны худаг гаргах / гар худаг ухах 2 хүн 800000, насос авах 2ш 1040000, талбайд суваг татах 10хүн 2000000/	2904000	0%
	Усалгааны шуудуй татах /шуудуй ухах 12хүн 48000, доторлох 2000000, тээврийн зардал 480000/	2960000	0%
	Нийт	21109000	0%

Хүн хүчний өртөг	Бусад хөрөнгө оруулалт
Их	Их
Дунд	Дунд
Бага	Бага

Тайлбар: Салхинаас хамгаалах ойн зурвасанд 3 ба түүнээс дээш настай, 1.5-2 м өндөртэй суулгацуудыг хэрэглэх бөгөөд

зурвасны хэлбэрээс (нягт, сиймхий, сийрэг) хамааруулан мод хооронд 2-5 м, эгнээ хооронд 4-6 м зайтайгаар тооцоолж тарих ба тарилтын хугацааг 4 дүгээр сарын хоёрдугаар хагас 5 дугаар сарын эхний 10 хоногоос хэтрэлгүй тарих шаардлагатай

Засаж сайжруулах үйл ажиллагаа	Урсгал зардал 1жилд /га-аар/		
	Гарах зардал	өртөг (US\$)	Газар ашиглагчаас гарах %
1. Тарьц суулгац арчлах	Арчлах		0%
2. Хамгаалалтын торон хашааг засах сэлбэх	Торон хашааг сэлбэх	1800000	0%
3. Ойн зурвасанд тарьсан мод сөөгний төрөл зүйлийг нэмэгдүүлэх	Нэмэлт тариалалт	1560000	0%
	Нийт		0%

Үнэлгээ

Үр ашиг /газар ашиглагчаас хамаарсан өртөг	Газар ашиглагчийн үзэж байгаагаар олсон ашиг	Богино хугацаанд	Урт хугацаанд
	Анх байгуулахад зарцуулагдсан зардалтай харьцуулахад олсон үр ашиг	Дунд зэрэг сараг	Эерэг
	Урсгал зардалтай харьцуулахад олсон үр ашиг	Дунд зэрэг Эерэг	Сөрөг

Технологийн нөлөөлөл

Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн үр ашиг

+ + Байгалийн гамшигийн эрсдэл буурсан

Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн алдагдал

Нийгэм соёлын үр ашиг

+ + Амралт, аялал жуулчлалын боломж нэмэгдсэн
 + + Хамгаалал доройтлын талаарх мэдлэг нэмэгдсэн

Нийгэм соёлын алдагдал

байхгүй

Экологийн үр ашиг

+ + + Хөрсний өнгөн давхарга сайжирсан
 + + + Хөрсний чийг нэмэгдсэн
 Биомасс нэмэгдсэн
 + + + Хөрсний органик бодис нэмэгдсэн
 Ургамлын төрөл зүйл нэмэгдсэн
 + + + Амьдрах орчин сайжирсан
 Салхины хүрд
 + + + Хөрсний үржил шим сайжирсан

Экологийн алдагдал

байхгүй

Дам үр ашиг

+ + Худаг

Дам сул тал

байхгүй

Давуу тал ба/буюу → хэрхэн тогтвортой байлгах/сайжруулах

Сумын төвд учрах байгалийн гамшигийн эрсдэл буурсан, амьдрах орчин сайжирсан → хамгаалалтын хашааг сэлбэн тордох, тарьсан модны тоо хэмжээг нэмэгдүүлэх ажлыг жил бүр төлөвлөгөөтэй хийж хэрэгжүүлэх

Салхи шуурганаас хааж оршин суугчдын сэтгэл санаа дээшилсэн → арчилгаа тордолгоог сайжруулж, айл өрх бүр мод тарьж, үржүүлэх

Сул тал ба/буюу → хэрхэн даван туулах

Сумын засаг даргын тамгийн газрын мэдэлд байгаа явдал → Хувь хүн, ТББ-ын мэдэлд шилжүүлэх

Зөвхөн улиас, бургас тарьсан явдал → Ашиг олох жимс, ногоо тариалах, худалдах

Холбоо барих байгууллага: ШУА-ийн Газараүй - Геоэкологийн хүрээлэн: Цөлжилтийн судалгааны салбар

Утас: 976-11-325487 **Факс:** 976-11-322187

Вебсайт: www.igq.ac.mn, www.geo-eco.mn